

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Хуучин чулуун зэвсгийн дээд үе шат он тооллын хувьд алинд нь хамаарах вэ? /1 оноо/  
A. 800.000-15.000  
B. 800.000-100.000  
C. 100.000-40.000  
D. 40.000-15.000  
E. Эдгээрээс өөр
2. Палеолитын /хуучин чулуун зэвсэг/ үед холбогдох хамгийн эртний хадны зураг аль нь вэ? /1 оноо/  
A. Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын хадны зураг  
B. Увс аймгийн Сагил сумын Можоогийн хадны зураг  
C. Ховд аймгийн Үенч сумын Ямаан усны хадны зураг  
D. Ховд аймгийн Манхан сумын Хойд цэнхэрийн агуйн хадны зураг  
E. Дорнод аймгийн Булган сумын Норовлингийн онго
3. Эртний хүмүүсийн хэрэглэж байсан зэвсгүүдээс аль нь чулуун зэвсгийн хамааралтай зөв өгөгдөл вэ? /1 оноо/  
A. Таргил, хянгар, нум сум  
B. Сүх, ойл, нум сум, бороохой  
C. Хугадас, хагадас, таргил, хянгар, үлдэц  
D. Шовх, үзүүр, жад, сэлэм  
E. Хүрэл, зэв, хутга
4. Монгол нутагт хүн амьдарч байсныг илтгэх хамгийн эртний олдвор аль вэ? /1 оноо/  
A. Нарийн гол 17Б бууц  
B. Можоогийн хадны зураг  
C. Тамсагбулагийн суурин  
D. Ноён уулын булш  
E. Норовлингийн дурсгал
5. Монгол нутагт хүрлийн үйлдвэрлэл он тооллын хувьд хэзээнээс хэдий үе хүртэл үргэлжилсэн бэ? /1 оноо/  
A. НТӨ I – НТӨ III мянган  
B. НТ III-НТ I зуун  
C. НТӨ III- НТӨ I мянган  
D. НТӨ I - НТ III мянган  
E. Тохирох хариулт алга
6. "901 Хятан аймгуудын холбооны тэргүүнээр /хан/ өргөмжлөгдөж, улмаар 917 онд улсаа тунхагласан Елюй овгоос гаралтай хаан хэн бэ? /1 оноо/  
A. Амбагян  
B. Могилян  
C. Таньшихуай  
D. Шэлүнь  
E. Түмэн
7. "... Миний дээд өвөг Буман хаан. Хүний хөвгүүдийг эзлэн сууж, Эл улсаа тэтгэн засаг төрийг бататгав. Өвөг Буман мэргэн хаан бөлгөө. Баатар хаан бөлгөө..." хэмээх бичээс нь аль улсын ямар түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн бэ? /1 оноо/  
A. Уйгур – Сэлэнгийн бичээс  
B. Түрэг – Культегиний хөшөө  
C. Хятан – Хэрлэн барс хотын суврага  
D. Уйгур – Долоодойн булшны хөшөө  
E. Тохирох өгөгдөл алга
8. Түүхэнд "Өндөр тэрэгтэн" хэмээн нэрлэгдсэн Уйгур улсыг үндэслэгч хаан хэн бэ? /1 оноо/  
A. Пейло  
B. Хэлян  
C. Модунь  
D. Хуханье  
E. Билгэ

9. Энэхүү түүхэн дурсгал эртний аль улсад хамаарах вэ? /2 оноо/

- A. Хүннү
- B. Нирун
- C. Түрэг
- D. Уйгур
- E. Хятан

10. Дарлигин Монголчууд хаанаас нүүдэллэн ирсэн хэмээн Судрын чуулганд өгүүлдэг вэ? /1 оноо/

- A. Онон мөрнөөс
- B. Тэнгэр уулнаас
- C. Агу хэмээх газраас
- D. Сэлэнгэ орчмоос
- E. Эргүнэ гүнгээс

11. 970-аад оны үед төрсөн, язгуур монгол аймгуудын дийлэнхийг зарим “эх захгүй иргэд”-ийн хамт захирч байсан Алунгоо хатны отгон хүү хэн бэ? /1 оноо/

- A. Бугу хатаги
- B. Бугути салжи
- C. Бодончар
- D. Бэлгүнүтэй
- E. Бүгүнүтэй

12. Язгуур монгол аймгийн нэгдлийг түүхэнд “Хамаг Монгол” гэж нэрлэдэг. Тэдний тухай мэдээг хятад сурвалжид 1084 онд хэрхэн тэмдэглэсэн бэ? /1 оноо/

- A. Да Мэн гу
- B. Шивэй
- C. Сүмбэ
- D. Сипинхэ
- E. Да Монгол

13. Хабул 1130 онд гол гурван аймгийн ихэс ноёдын хуралдайгаар Хамаг Монголын хаанд өргөмжлөгдсөн оныг зууны тоололд шилжүүлсэн зөв өгөгдлийг олно уу? /2 оноо/

- A. XII зууны II хагас
- B. XII зууны I хагас
- C. XIII зуун
- D. XI зуун
- E. Тохирох хариулт алга

14. Эртний сурвалжит Хэрэйдийн ханлигийн хан аль нь вэ? /1 оноо/

- A. Таян хан
- B. Хүчлүг хунтайж
- C. Тогтоа бэхи
- D. Тоорил хан
- E. Хаатай Дармала

15. 1206 онд Монгол ноёдын их хуралдай хуралдаж, Их Монгол улс байгуулагдсаныг зарлан Чингис хааныг эрдэнийн ширээнд залав. Энэ үйл явдал хаана болсон бэ? /1 оноо/

- A. Онон мөрний эхэн
- B. Хэрлэний Хөдөө арал
- C. Тамирын Шар орд
- D. Хархорум
- E. Хар зүрхний Хөх нуур

16. Их Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын талаар доорх бодомжуудад буруу зүйл орсон бол олно уу. /2 оноо/

- A. Төрийн бүх дээд эрхийг баригч нь Чингис хаан байв.
- B. Их хуралдайгаар хаан өргөмжлөх, харь оронтой дайтах, найрамдах зэрэг төрийн онц чухал хэргийг шийддэг.
- C. Сэцдийн зөвлөл нь хаан ба их хуралдайн үйл ажиллагаанд зөвлөн туслах үүрэгтэй.
- D. Төрийн шадар сайд /Гоо ван/ эрүү, иргэний асуудлуудыг шүүн тасалдаг их заргач юм.
- E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.

17. Эдгээрээс Чингис хааны 9 өрлөгт үл хамаарах өгөгдөл аль вэ? /2 оноо/

- A. Мухулай, Боорчи
- B. Зэлмэ, Шихихутаг
- C. Сорхон шар, Сүбээдэй
- D. Хубулай, Чулуун
- E. Зэв, Хар Хирүгэ

18. “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын далай хааны зарлиг. Эл булха иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай” хэмээх бичээс нь аль түүхэн эх сурвалжид хамаарах вэ? /2 оноо/
- A. Гүюг хааны тамганы бичээс  
C. Гэрэгэ, пайзны бичээс  
E. Аргун хаанаас Францын Гоо Филиппт явуулсан захианы бичээс
- B. Чингисийн чулууны бичээс  
D. Мөнх хааны хөшөөний бичээс
19. Алтан ордны улсын нийслэл нь Сарай хот бөгөөд Эрчис мөрнөөс баруун зүг Днепр мөрөн, зүүнтээ Болгар, умард тал нь Крым, Кавказын нутагт хүрч байжээ. Чингис хаан аль хүүдээ дээрх эзэмшил нутгаа хувь өмч болгон өгсөн бэ? /1 оноо/
- A. Зүчи  
E. Тохирох өгөгдөл алга
- B. Цагаадай  
C. Өгөөдэй  
D. Тулуй
20. “Орчлонгийн элдэв сонин” түүхэн зохиол хэний бүтээл вэ? /1 оноо/
- A. Вильгельм Рубрук  
D. Плано Карпини
- B. Марко Поло  
E. Рашид- ад Дин
- C. Ата- Малик Жувейн
21. Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, үйл ажиллагаанд хамаарах зүйлийг нэрлэнэ үү. /2 оноо/
1. Бээжингийн зүүн хойно 1267 оноос шинэ хот Ханбалигийг бариулсан.
  2. Буддын шашныг төрийн шашин болгосон.
  3. Бирм, Камбож, Аннамыг байлдаж “түшмэг” улс болгосон.
  4. Хархорум хотын мөнгөн модыг бүтээсэн.
  5. Монголын нууц товчоог зарлигаар зохиолгосон.
  6. Марко Полог Хархорумд захирагчаар суулгасан.
- A. 1, 2,3  
B. 5, 6  
C. 4, 5, 6  
D. 4,5  
E. 5,7
22. Алтан ордны улсын нийслэл аль вэ? /1 оноо/
- A. Самарканд хот  
E. Сарай хот
- B. Султани хот  
C. Тебриз хот  
D. Бээжин хот
23. Хубилай хаан Япон улсад хэдэн онд анх довтолсон бэ? /1 оноо/
- A. 1260  
B. 1261  
C. 1274  
D. 1290  
E. 1294
24. Монголын Юань улсыг үндэслэгч хэн бэ? /1 оноо/
- A. Аригбөх  
E. Өлзийттөмөр
- B. Хубилай  
C. Хүлэгү  
D. Бат
25. Алтан ордны улсын түүхэнд холбогдох өгөгдлийг нэрлэнэ үү. /1 оноо/
- A. Сарай хот  
D. Астраханы хант улс
- B. Бат, Бэрх  
E. Дээрх бүгд хамаарна
- C. Ногайн орд
26. Улс төрийн бутрал хэзээнээс хэдий хүртэл үргэлжилсэн бэ? /1 оноо/
- A. 1368-1634  
D. 1604-1634
- B. 1333-1368  
E. XIII зуун
- C. 1454-1455
27. Зургаан түмэн Монголын Зүүн түмэнд аль нь орж байсан бэ? /2 оноо/
- A. Ордос, Еншөөбү, Түмэд  
C. Халх, Цахар, Урианхай  
E. Эдгээрээс өөр
- B. Цорос, Торгууд, Хошууд  
D. Хойд, Баатууд, Барга

28. Ойрадын Эсэн тайш 1449 онд Мин улсад довтолж, Ин-зун хааныг олзолсон байдаг. Тэгвэл энэхүү үйл явдлыг түүхэнд юу гэж тэмдэглэсэн бэ? /2 оноо/

- A. Түмогийн хэрэг                      В. Дөчин дөрвөн хоёр нэг хааны алдар болов.  
C. Гар газар, хөл хөсөр үе        D. Эсэн хааны үе  
E. Дээр хөхрөгчид наран саран, доор ногоорогчид хаан жонон

29. Түүхэнд Лигдэн хаан ямар цолоор алдаршсан бэ? /1 оноо/

- A. Билэгт                                      В. Хутагт                                      С. Засагт  
D. Элбэг нийгүүлсэгч                      Е. Бошигт

30. Дараах ойлголтуудыг түүхэн утгаар нь тохируулна уу. /2 оноо/

- A. Түмэн засагт хаан                      1. Төвөдийн Гармаа ламыг залав.  
B. Автай сайн хан                          2. 1586 онд Эрдэнэ зуу хийдийг байгуулав.  
C. Түмэдийн Алтан хан                      3. Төвөдийн Содномжамцыг залж, Далай лам цол өгөв.

- A. a1,b2,c3                      В. a1,b3,c2                      С. a2,b1,c3                      D. a3, b2, c1  
E. a3,b1,c2

31. 1639 онд Халхын ноёд чуулж Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг 5 настайд нь Халхын шарын шашны тэргүүнээр өргөмжлөв. Энэ нь аль чуулганаар болсон үйл явдал вэ? /2 оноо/

- A. Улаан бураагийн чуулган                      В. Ар Элстэйн чуулган  
C. Хүрэн бэлчирийн чуулган                      D. Мүгдэний чуулган  
E. Ширээ цагаан нуурын чуулган

32. Монголын нэгэн хаан Манжийн Нурхачид бичсэн захидалд өөрийгөө “Дөчин дөрвөн Монголын эзэн”, түүнийг “Мөрөн голын хөвөөнд суух гурван түмнийг захирсан өчүүхэн хаан” гэж бичсэн байдаг. Аль хааны захидал вэ? /1 оноо/

- A. Лигдэн                                      В. Галдан                                      С. Аюушридар  
D. Цэвээнравдан                                      Е. Төрбайх

33. 1755-1758 оны зэвсэгт бослогын гол удирдагчид болох Амарсанаа, Чингүнжав, Сэвдэнбалжир нарын хүчийг салгах арга хэмжээг Манж нар авсан байдаг. Амарсанаатай хамаарах нь аль нь вэ? /2 оноо/

- A. Хан- Хатан голын Тэлэнгид нарыг дагуулах үүрэг өгсөн.  
B. Гэрийн хорионд оруулж бослого явуулах боломжийг хаасан.  
C. Хэрэг зөвлөнө гэж Бээжинд дуудсан ч эзэн хаанд бараалхана хэмээн гарч тэмцсэн.  
D. Өвөр Монголыг эзлэх үүрэг өгсөн.  
E. Тийм зүйл алга.

34. Манжийн төрийн олон зүйлийн хүнд хүчир албанд зүтгэдэг цэрэг эр аль давхаргад багтах вэ? /1 оноо/

- A. Ноёд, язгууртнууд                      В. Хамжлага, ард                      С. Суман эр  
D. Шавь ард                                      Е. Тохирох хариулт алга

35. Монголчуудын зүгээс Манж Чин улсад залгуулдаг төрөл бүрийн алба дотроос хамгийн хүнд хүчир нь ямар алба байсан вэ? /2 оноо/

- A. Есөн цагааны алба                      В. Бээжинд жасаалах                      С. Сүрэг адуулах алба  
D. Тариалангийн алба                      Е. Өртөөний алба

36. Дараах түүхэн үйл явдлуудыг зүй тогтлоор нь зөв дараалалд оруулна уу. /2 оноо/

1. Олноо өргөгдсөн Монгол улсыг байгуулсан.  
2. Гурван улсын гэрээ байгуулсан.  
3. Чен – И –гийн 64 зүйл боловсруулсан.  
4. Шинэ толь сэтгүүл хэвлэгдсэн.  
5. Гадаад Монголын автономийг устгасан.

- A. 1, 4, 2, 3, 5,                      В. 2, 4, 5, 3, 1                      С. 1, 2, 3, 4, 5                      D. 5, 4, 3, 2, 1                      Е. 5, 3, 1, 4, 2

37. Дараах ойлголтуудыг түүхэн утгаар нь харгалзуулна уу. /2 оноо/

- |   |                 |
|---|-----------------|
| A. Жалханз хутагт буюу монгол улсын Ерөнхий сайд  | 1. Дамдинбазар  |
| B. 1915 оны гэрээнд оролцогчдыг ахласан Жонон ван | 2. Ширнэндамдин |
| C. Хөлөн Буйрын Баргын хошууны сумын занги        | 3. Дамдинсүрэн  |
| D. Богд хаанаас “Зоригт баатар” цолоор шагнагдсан | 4. Тогтох       |
| E. Монгол улсын анхны Ерөнхий сайд                | 5. Намнансүрэн  |

- |                       |                       |                       |
|-----------------------|-----------------------|-----------------------|
| A. a2, b1, c5, d4, e3 | B. a1, b2, c3, d4, e5 | C. a5, b1, c2, d3, e4 |
| D. a3, b4, C1, d5, e2 | E. a4, b1, c3, d2, e5 |                       |

38. VIII Богд хааны эрх хэмжээнд хамаарахгүй зүйлийг олно уу. /1 оноо/

- A. Улсын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх
- B. Дээд тушаалтныг томилох, огцруулах
- C. Цол, хэргэм, зэргээр шагнах
- D. Яамдын сайдын үүргийг хавсран гүйцэтгэх
- E. Элч төлөөлөгч илгээх

39. 1920 оны 8 сард “Анхны долоо” Эрхүү хотноо очжээ. Эрхүүд үлдсэн Д.Сүхбаатар, Х. Чойбалсан нар ямар үүрэгтэй байсан бэ? /1 оноо/

- A. Нийслэл Хүрээний байдлыг ажиглан суух
- B. Хоёр талтай харилцах, цэргийн хэрэгт боловсрох
- C. Коминтерн, ОК/Б/ Н, Зөвлөлтийн бодлого, үйл ажиллагаатай танилцах
- D. Зөвлөлт Орос улсын удирдагчтай уулзах
- E. B ба C хариулт зөв

40. Ардын намын цэрэгт Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошуунаас элсүүлсэн хүмүүсийг ямар цэрэг хэмээн нэрийддэг байсан бэ? /1 оноо/

- |                |                 |                |
|----------------|-----------------|----------------|
| A. Шадар цэрэг | B. Цоохор цэрэг | C. Хошуу цэрэг |
| D. Цахар цэрэг | E. Торгон цэрэг |                |

41. Ардын журамт цэрэг Хиагтыг хэзээ гамингаас чөлөөлсөн бэ? /1 оноо/

- |               |              |              |
|---------------|--------------|--------------|
| A. 1921.3.1-3 | B. 1921.3.13 | C. 1921.3.18 |
| D. 1921.7.9   | E. 1921.7.10 |              |

42. 1923 оны засаг захиргааны өөрчлөлтөөр Дөрвөдийн хоёр аймгийг хэрхэн нэрлэсэн бэ? /1 оноо/

- |                          |                                |                         |
|--------------------------|--------------------------------|-------------------------|
| A. Богд хан уулын аймаг  | B. Хан Хэнтий уулын аймаг      | C. Чандмань уулын аймаг |
| D. Хантайшир уулын аймаг | E. Цэцэрлэг мандал уулын аймаг |                         |

43. “...юун хэмээвээс ертөнцийн хүн төрөлхтөн бүгдээр найрамдах буюу зөвлөлдөх мэтсийн олон зэрэг дэс байр байх бөгөөд үлгэрлэвээс, авирах гишгүүрт нэгээс үүсгэн дэвших ба усанд гүехэнээс гүнд орохоор одохын утга адил буй...” гэсэн С.Данзангийн үзэл бий. Дээрх түүхэн баримтын агуулгад нийцүүлэн хийсэн дүгнэлтэд аль нь хамаарах вэ? /2 оноо/

- A. Нийгмийн хөгжлийн үе шатыг алгасахгүй дэвшинэ.
- B. Хүн төрөлхтний жам ёсны үе шатыг дамжин дэвшинэ.
- C. МАН-ын эцсийн зорилт бол эв хамтын ёс мөн.
- D. Хөгжлийн үе шатыг алгасах замаар хөгжинэ.
- E. A ба B хамаарна.

44. “Дахин баяжигтун” уриаг дэвшүүлж, шинэ баруунтан гэгдэж байсан төрийн зүтгэлтэн хэн бэ? /1 оноо/

- |              |                |              |
|--------------|----------------|--------------|
| A. Б.Шмераль | B. Ж.Цэвээн    | C. М.Амагаев |
| D. П.Гэндэн  | E. Б.Цэрэндорж |              |

45. 1930 оны 12 сард худалдаа, жин тээвэр эрхлэлтэд төрийн давамгайл байдал бий болсон байдаг. Энэ нь аль ойлголтоор илэрхийлэгдэх вэ? /2 оноо/

- |  |                           |
|--|---------------------------|
| A. Онцгой бүрэн эрхт комисс            | B. Улсын онц эрх          |
| C. Феодал агсдын хөрөнгө хураах комисс | D. Шинэ эргэлтийн бодлого |
| E. C ба D                              |                           |

46. 1932 оны зэвсэгт босогчид тэрс буруу номтныг дарах үйл ажиллагаагаа юу гэж нэрлэж байсан бэ? /1 оноо/  
A. Шамбалын дайн B. Иргэний дайн C. Лам нарын бослого  
D. Эсэргүү бослого E. Эдгээрээс өөр
47. Албан баримтаар нийт 17000 орчим лам нарыг баривчилж, 13680 гаруй ламыг хороон бусдыг нь хорьж, 700 гаруй сүм хийдийг эвдлэн устгасан байдаг. Энэхүү “Их хэлмэгдүүлэлт” аль хугацаанд хамаарах вэ? /1 оноо/  
A. 1936-1940 B. 1937-1939 C. 1938-1939  
D. 1938-1940 E. Эдгээрээс өөр
48. Дараах бодомжуудаас зөв өгөгдлийг олно уу. /2 оноо/  
A. Фашист Герман 1945 оны 5 сарын 9-нд бууж өгсөн.  
B. ЗСБНХУ 1945 оны 8 сарын 9-нд Японд дайн зарласан.  
C. БНМАУ 1945 оны 8 сарын 10-нд Японд дайн зарласан.  
D. Япон 1945 оны 9 сарын 2-нд үг дуугүй бууж өгөх актанд гарын үсэг зурсан.  
E. Дээрх бүгд зөв бодомж
49. “Бэлэглэлийн төв комисс” байгуулагдаж, улмаар 1943 оны эцсээр “Ла-5” маркийн 12 онгоцноос бүрдсэн нисэх онгоцны эскадрилийг Улаан армид шилжүүлэн өгсөн. Аль өгөгдөл хамаарах вэ? /2 оноо/  
A. Монгол ард B. Хувьсгалт монгол C. Онцгой бүрэн эрхт комисс  
D. Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл E. Эдгээрээс өөр
50. 1962 онд НТХ-ны нарийн бичгийн дарга Д. Төмөр-Очир Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойн хүрээнд Чингис хааны зурагтай марк гаргаж, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, төрөлх нутаг Хэнтий аймгийн Дадал суманд гэрэлт хөшөө босгосон. Д.Төмөр-Очирыг хэрхэн буруутгаж, нам төрийн удирдлагаас зайлуулсан бэ? /2 оноо/  
A. Нэг намын ноёрхлыг дэмжсэн. B. Намын эсрэг бүлэг байгуулсан.  
C. Үндсэрхэг үзлийг дэвэргэсэн. D. Боловсон хүчнийг хяхан хавчсан.  
E. Мэдлэг нимгэн, хоцрогдсон.
51. “Малчид, хөдөлмөрчид бэлчээрийг үнэ төлбөргүй эдлэх, эмчлүүлэх, сурах, тэтгэвэр тэтгэмж авах, эвлэлдэн нэгдэх, шүтэх, эс шүтэх, хэвлэн нийтлэх” зэрэг эрх, эрх чөлөөг хуульчлан тунхагласан хэдий ч тоталитар дэглэмийн үед бүрэн хэрэгжих нөхцөлгүй байсан юм. Аль баримт бичигт тусгагдсан бэ? /2 оноо/  
A. 1924 оны Үндсэн хууль B. 1940 оны Үндсэн хууль  
C. 1960 оны Үндсэн хууль D. 1992 оны Үндсэн хууль  
E. Намын IV программ
52. Социализмын үеийн эдийн засгийн амьдралын хүрээн дэх онцлог шинжүүдийг дурдахдаа буруу бодомж оруулсан бол аль нь вэ? /2 оноо/  
A. Улсын өмчийг задлаж, олон хэвшил бүхий эдийн засгийг бий болгосон.  
B. Төвлөрсөн төлөвлөгөө бүхий эдийн засгийн удирдлагатай.  
C. Гадаад худалдаа нь социалист системээр хязгаарлагдсан.  
D. Үйлдвэрийн газар нь улсын төлөвлөгөө, норм биелүүлдэг.  
E. Хатуу үнийн систем үйлчилдэг.
53. “Азарганы ноцолдоон”, “Гүүн зэлэн дээр”, “Нэгдлийн гишүүд” зэрэг уран зургууд хэний бүтээл вэ? /1 оноо/  
A. Г. Одон B. Н.Чүлтэм C. М. Цэмбэлдорж  
D. О. Цэвэгжав E. Д. Дамдинсүрэн

54. 1990 оны 7 сарын 29-нд ямар түүхэн үйл явдал болсон бэ? /2 оноо/  
A. Монголд анх удаа олон намын оролцоотой чөлөөт ардчилсан сонгууль болсон.  
B. Монголын ардчилсан холбоо байгуулагдсанаа зарласан.  
C. Монгол улсын шинэ Үндсэн хууль баталсан.  
D. Нам, төрийн удирдлага ба шинэ хүчний удирдагчдын оролцсон “Дугуй ширээний ярилцлага” болсон.  
E. Монголын ардчилсан холбооны гишүүд дэмжигчид улс төрийн өлсгөлөн зарлав.

55. Бараа үйлчилгээний үнийн эцсийн чөлөөлөлтийг 1996 онд хэний Засгийн газар хийсэн бэ? /2 оноо/  
A. Д. Бямбасүрэнгийн Засгийн газар  
B. М.Энхсайханы Засгийн газар  
C. Ц.Элбэгдоржийн Засгийн газар  
D. Ж.Наранцацралтын Засгийн газар  
E. П. Жасрайн Засгийн газар

56. Монгол улсын шинэ Үндсэн хуулинд Ерөнхийлөгчийг хэрхэн нэр дэвшүүлэхээр заасан бэ? /2 оноо/  
A. Бие дааж нэр дэвшиж болно.  
B. Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намуудаас нэр дэвшүүлнэ.  
C. Улсын их хуралд суудалтай намууд дангаараа ба хамтран нэр дэвшүүлнэ.  
D. Ард түмэн өөрснөө нэр дэвшүүлнэ.  
E. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэр дэвшүүлнэ.

### ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

1. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
2. Зөв хариулт бүр нэг оноотой.

- 2.1. Монголын түүх, археологийн дараах дурсгалууд олдсон газрыг одоогийн аймаг нутгаар нь тохируулан нэрлэнэ үү. /5 оноо/

- A. Цагаан агуй /палеолит/
- B. Тамсагбулагийн суурин /неолит/
- C. Тэвш уулын хадны зураг /хүрэл, төмрийн эхэн/
- D. Ясан хэл хуур хөгжим /Хүннү/
- E. Билгэ хааны алтан титэм /Түрэг/

- 2.2. Дараах ойлголтуудыг түүхэн утгаар нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

- A. Тамга үсэг, 12 жилийн он тоолол, аравтын систем
  - B. Уйгур бичиг, манихайн шашин, Хар балгас
  - C. Руни бичиг, хүн чулуу, төмөр боловсруулалт
  - D. Их, бага бичиг, Бор хот, хот байгуулалт
  - E. Хоёр ёсны үзэл, Мөөмт хот, төрийн шашин будда
- 1. Хүннү
  - 2. Нирун
  - 3. Түрэг
  - 4. Уйгур
  - 5. Хятан

- 2.3. Монгол улсын дараах Ерөнхий сайдуудыг уг албанд ажиллаж байсан он цагийн дарааллаар нь эрэмбэлнэ үү. /1-5 хүртэл дугаарлана / /5 оноо/

- A. А.Амар
- B. Т.Намнансүрэн
- C. Д.Бодоо
- D. Х.Чойбалсан
- E. Б.Цэрэндорж

- 2.4. Дараах түүхэн үйл явдлуудыг цаг хугацаагаар нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

- A. Улиастайд 2000 цэргийн бослого гарсан.
  - B. Олноо өргөгдсөн Монгол улсыг тунхагласан.
  - C. Ардын журамт цэрэг Хиагтыг чөлөөлсөн.
  - D. Ардын эрхт, хэмжээт цаазат хаант улсыг тунхагласан.
  - E. Анхдугаар Үндсэн хуулийг баталж, Бүгд найрамдах засгийг тунхагласан.
- 1. 1911.12.29
  - 2. 1921.3.18
  - 3. 1924.11.26
  - 4. 1900 он
  - 5. 1921.7.11